



“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 29 -ны өдөр

Дугаар №1

Улаанбаатар хот

**Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
төлөөлөн удирдэх зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.11 заалт, “Монгол Базальт” хувьцаат компанийн 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:



А.ЭНХГЭРЭЛ



“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 29 -ны өдөр

Дугаар №2

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүнийг сонгох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.9 дэх заалт, компанийн 2019 оны 4 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ. “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

1. Лхагжав овогтой Ариунболд
2. Галбадрах овогтой Ганзориг
3. Ариунболд овогтой Энхгэрэл
4. Пүрэвбанзрагч овогтой Сайнбилэг
5. Бадарч овогтой Шаравсамбуу
6. Хан Гю Бунг /Хан Куу Bong/

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

1. Шаравсамбуу овогтой Энхтөр
2. Чансаа овогтой Зоригтбаатар
3. Түвшинтөр овогтой Цэнд-Аюуш нарыг тус тус сонгосугай.

ХОЁР. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм, дотоод журмуудад заасан үүргээ хариуцлагатай гүйцэтгэж, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



А.ЭНХГЭРЭЛ



“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 29 -ны өдөр

Дугаар №3

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.15 дах заалт, компанийн 2019 оны 4 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базальт” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг сар бүрт нь тооцон олгохыг Ерөнхий нягтлан бодогч-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



А.ЭНХГЭРЭЛ

“Монгол Базальт” ХК-ийн 2019 оны 4 сарын 29-ны өдрийн хувьцаа
эзэмшигчдийн ээлжит хурлын 3 тоот тогтоолын хавсралт

“Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ

ТУЗ-ийн гишүүдийн цалин		Хэмжээ /төгрөг/
Тогтмол цалин	Үндсэн	400,000 ₮
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	200,000 ₮
	Хорооны даргын нэмэгдэл	100,000 ₮
Оролцоонд үндэслэсэн нэмэгдэл цалин	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд биечлэн оролцсон тоогоор	100,000 ₮

Хурлууд:	Хурлын давтамж, тоо
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	Жилдээ 1 удаа
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал	Жилдээ 4 удаа
ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны хурал	Жилдээ 4 удаа
ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны хурал	Жилдээ 2 удаа
ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны хурал	Жилдээ 1 удаа



“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 29 -ны өдөр

Дугаар № 4

Улаанбаатар хот

Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх эсэх

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.12 дэх заалт, 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2, “Монгол Базалт” ХК-ийн дүрмийн 6.1.5.14 дэх заалт, компанийн 2019 оны 4 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу “Монгол Базалт” ХК нь өөрийн гаргасан энгийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн эргүүлэн худалдаж авах нөхцөл, хувь хэмжээ, үнэ, эргүүлэн худалдан авах журмыг боловсруулж батлах, үнэт цаасыг эргүүлэн худалдан авахтай холбогдсон шийдвэр гаргах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
3. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн авсан тохиолдолд хувьцаа эзэмшигчид зар хүргэх, эргүүлэн худалдан авсан үнэт цаасны мэдээллийг танилцуулж байхыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



А.ЭНХГЭРЭЛ



“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 4 сарын 29 -ны өдөр

Дугаар № 5

Улаанбаатар хот

Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг батлах

Компанийн 2019 оны 4 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базалт” ХК-ийн үйлдвэрийн хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг хавралт 3-аар баталсугай.
2. Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг хариуцан гүйцэтгэх, хувьцаа эзэмшигчдийг мэдээлэл хүргэх, танилцуулах үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



А.ЭНХГЭРЭЛ